

ТАНИЛЦУУЛГА

Цөмийн зэвсгийг хориглох тухай гэрээний тухай

Монгол Улсын аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар хангах тухай гадаад бодлогын зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд манай улс нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй статус хэмээн 1992 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 47 дугаар чуулганы үеэр зарласан. Өнгөрсөн 29 жилийн хугацаанд статусаа эрх зүйн үндэстэй болгон баталгаажуулахад чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулж ирлээ.

Тухайлбал, "Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус"-ын тухай тогтоолыг анх 1998 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 53 дугаар чуулганаар батлуулсан. Үүнээс хойших хугацаанд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаас тогтоолын хэрэгжилтийн талаар илтгэл гаргаж, тогтоолыг 2 жил тутам батлуулж байна.

Мөн НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын 5 гишүүн Монгол Улсын цөмийн зэвсэггүй статустай холбогдуулан 2000 оны 10 дугаар сард Хамтарсан мэдэгдэл гаргаж, тус статуст баталгаа олгосон Хамтарсан тунхаглалд 2012 онд гарын үсэг зурсан.

Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай (Treaty on the non-proliferation of the nuclear weapons-1968) гэрээг Монгол Улс 1969 онд, Цөмийн туршилтыг бүрэн хориглох тухай (Comprehensive Nuclear-Test-Ban Treaty-1996) гэрээг 1997 онд тус тус соёрхон баталсан.

Улмаар цөмийн зэвсэггүй статусаа тодорхойлон бататгасан дотоодын эрх зүйн акт гаргах шаардлага гарч ирсэн бөгөөд 2000 онд Монгол Улсын Их Хурал Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 19 дүгээр тогтоолыг, 2015 онд Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай 60 дугаар тогтоолыг батлаад байна.

Гэрээний тухай

Цөмийн зэвсгийг хориглох тухай гэрээ байгуулах асуудлаарх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн A/RES/71/258 тоот тогтоолыг 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн бүгд хуралдаанаар санал хураалт (128/29/18)-аар баталсан¹.

Энэхүү тогтоолын дагуу Гэрээний төслийг хэлэлцэх бага хурлыг 2017 оны 3 дугаар сарын 27-31-нд, 6 дугаар сарын 15-наас 7 дугаар сарын 7-нд НҮБ-ын Төв байранд зохион байгуулсан. Бага хуралд 124 улс (Палестин, Ватиканы Гэгээн ширээт улсын төлөөлөгчид бусад гишүүн орны адил санал өгөх бүрэн эрхтэйгээр) оролцсон. Тус гэрээг батлах санал хураалтад 122 улсын дэмжиж, 1 улс эсрэг (Нидерланд), 1 улс түдгэлзсэн (Сингапур) санал өгч баталсан². Нийт 69 улс, түүний дотор цөмийн зэвсэгтэй бүх орнууд, НАТО-гийн гишүүн орнууд (Нидерландаас бусад) санал хураалтад оролцоогүй.

¹ Монгол Улс тогтоолын "төлөө" санал өгсөн.

² Монгол Улс гэрээний төслийг дэмжиж, "төлөө" санал өгсөн.

Уг гэрээнд 2021 оны 5 дугаар сарын байдлаар 86 улс гарын үсэг зурсан, 54 улс соёрхон баталсан, эсхүл нэгдэн орсон байна.

Энэхүү гэрээний 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн дагуу гэрээг 50 улс соёрхон баталсан тул 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

Цөмийн зэвсгийг хориглох тухай гэрээний үндсэн зорилго нь улс орнуудыг цөмийн зэвсгээ хураахад нөлөөлөх, цөмийн зэвсгийг үр дүнтэй, баталгаатай, эргэж буцалтгүйгээр, цаг хугацаа зааж устгахад дөхөм үзүүлэх, цаашид дэлхийн хэмжээнд цөмийн зэвсгийг устгахад хувь нэмрээ оруулах, цөмийн зэвсгийг ашиглахгүй, эзэмшихгүй байх хэм хэмжээг тогтооход оршино.

Гэрээ нь цөмийн эрчим хүчийг хөдөө аж ахуй, анагаах ухаан, шинжлэх ухаан, эрчим хүч үйлдвэрлэх зэрэг энхийн зорилгоор ашиглахыг бүрэн дэмжсэн. Гэрээний хориглох, үүрэг хүлээлгэх, хэрэгжүүлэх заалт нь гэрээний хүмүүнлэгийн зорилго, цөмийн зэвсгийн эсрэг олон улсын хэм хэмжээг бэхжүүлэхэд чухал үүрэгтэй байх юм.

Цөмийн зэвсгийг хориглох тухай гэрээ нь оршил 24, тогтоох 20 зүйлээс бүрдэж байгаа.

Гэрээний оршил хэсэгт цөмийн зэвсгийг бүрэн устгах нь түүнийг хэзээ ч, ямар ч нөхцөлд дахин хэрэглэхгүй байх цорын ганц баталгаа мөн, цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглах үүднээс судалгаа хийх, үйлдвэрлэл явуулах, эрчим хүчийг ашиглах нь гишүүн орнуудын салшгүй эрхийг хөндөхгүй байх, бүс нутгийн орнуудын байгуулсан цөмийн зэвсгээс ангид бүсүүд нь дэлхийн болон бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлж, цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх дэглэмийг бататган, цөмийн зэвсгийг хураах зорилгыг хэрэгжүүлэхэд бодит хувь нэмэр оруулна гэдгээ нотолсон заалтыг тусгажээ.

Гэрээний 1 дүгээр зүйлд цөмийн зэвсэг, эсхүл цөмийн аливаа төрлийн тэсрэх төхөөрөмжийг хөгжүүлэх, турших, үйлдвэрлэх, бэлдэх болон өөр бусад хэлбэрээр худалдаж авах, эзэмших, эсхүл хадгалах, цөмийн зэвсэгтэй холбоотой гэрээгээр хориглосон аливаа үйлдлийг дэмжих, туслах, цөмийн зэвсгийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, өөрийн газар нутаг дээр байршуулах, суурилуулахыг хориглосон.

Гэрээний 2 дугаар зүйлээр оролцогч тал бүр цөмийн зэвсэг эсхүл цөмийн бусад тэсрэх төхөөрөмж эзэмшиж, мэдэлдээ буюу хяналтдаа байлгасан эсэх, цөмийн зэвсэгтэй холбоотой бүх байгууламжаа устгасан эсэхээ зарлан мэдэгдэх үүргийг хүлээж буй.

Гэрээний 3 дугаар зүйлд гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөж байсан Олон улсын атомын энергийн агентлагын Иж бүрэн баталгааны хэлэлцээрээр хүлээсэн үүргээ хадгалж үлдээх, 4 дүгээр зүйлд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор бусад улстай хамтран ажиллах, цөмийн зэвсэг, эсхүл цөмийн бусад төрлийн тэсрэх төхөөрөмжийн ажиллагааг бэлэн байдлаас нь нэн даруй гаргах, устгах, хөрвүүлэх зэрэг ажлыг тодорхой төлөвлөгөөний дагуу хийх, үүнтэй холбоотой үүргээ биелүүлсэн тухайгаа мэдэгдэх зэргийг тусгажээ.

Гэрээний 5 дугаар зүйлд гэрээний үүргээ биелүүлэх, хориглосон аливаа үйл ажиллагаа явуулахаас урьдчилан сэргийлэх, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх, 6 дугаар зүйлд цөмийн зэвсгийн туршилтад өртсөн, хохирсон хүмүүст эмнэлгийн, сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх, цөмийн туршилтын үр дүнд бохирдож сүйдсэн газар нутгийг нөхөн сэргээх, 7 дугаар зүйлд гэрээг хэрэгжүүлэхийн тулд оролцогч улсуудтай хамтран ажиллах, техникийн тусламж үзүүлэх, авах эрх, үүргийг хүлээж байгаа.

Гэрээний 8-9 дүгээр зүйлд гэрээний хэрэгжилтэй холбоотой оролцогч талуудын уулзалт, хянан хэлэлцэх бага хурлыг зохион байгуулах, зардлыг хариуцах зохицуулалт, 10-18 дугаар зүйлд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг тайлбарлах, хэрэглэхтэй холбогдон гарах маргааныг шийдвэрлэх, гэрээнд гарын үсэг зурах, соёрхон батлах, хүчин төгөлдөр болох, гэрээний хугацаа, гэрээнээс гарах нөхцөл зэргийг тодорхой заасан.

Гэрээний төгсгөл 19-20 дугаар зүйлд гэрээний эх хадгалагч нь НҮБ-ын ЕНБД байх, гэрээний эх бичвэрийн талаар дурджээ.

Гэрээний эдгээр зохицуулалтыг манай улс дотоодын хууль тогтоомждоо тусгасан бөгөөд Цөмийн зэвсгээс ангид байх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт хувь хүн болон хуулийн этгээд, гадаад улс цөмийн зэвсэг, эсхүл цөмийн аливаа төрлийн тэсрэх төхөөрөмжтэй холбогдсон үйлдэл, үйл ажиллагаа явуулах, санаачлан хэрэгжүүлэх буюу хэрэгжүүлэхэд оролцохыг хориглосон байдаг.

Стратегийн зэвсэг болох цөмийн зэвсгийг хураах, үл дэлгэрүүлэх, хянах асуудлыг Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээ, Цөмийн туршилтыг бүрэн хориглох гэрээний хүрээнд зохицуулж байна.

Цөмийн зэвсгийг хориглох чиглэлээрх яриа хэлэлцээний дүнд энэхүү гэрээг баталсан нь цөмийн зэвсэггүй дэлхий ертөнцийн төлөө нэг алхам урагшилсан чухал үйл явц болсон. Хэдийгээр цөмийн зэвсгийн аюул заналхийлсээр байгаа, цөмийн зэвсгийг устгахад урт, удаан хугацаа шаардлагатай байгаа хэдий ч гэрээ нь дээрх зорилгод хүрэх итгэл найдварыг хүн төрөлхтөнд өгч байгаа нь чухал юм.

Монгол Улс цөмийн зэвсгийг хориглох, түүнийг бүрмөсөн устгахад чиглэсэн олон улсын эрх зүйн баримт бичиг байгуулах яриа хэлэлцээг болон энэ асуудалтай холбоотой НҮБ-ын холбогдох тогтоол, шийдвэрийг дэмжиж ирсэн улсын хувьд энэ байр сууриа нотлох нь зүйтэй байна.

Тус гэрээний зүйл, заалтууд нь үндэсний аюулгүй байдлын язгуур ашиг сонирхолыг хангаж, Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой бүрэн нийцэж байгаа.

Манай улс гэрээг соёрхон баталснаар цөмийн зэвсгийг хураах, үл дэлгэрүүлэх чиглэлээр баримталж ирсэн байр сууриа бататгах, энэ чиглэлийн яриа хэлэлцээ, хурал, арга хэмжээнд идэвхтэй оролцоход ач холбогдолтой юм.

Цөмийн зэвсэгтэй гэж албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын 5 гишүүн АНУ, ОХУ, БНХАУ, Франц, ИБУИНВУ, мөн олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөөгүй цөмийн зэвсэгтэй Энэтхэг, Пакистан, БНАСАУ ийм төрлийн зэвсгийнхээ тоо, хэмжээ, зөөгч хэрэгслийг нэмэгдүүлэхэд анхаарсаар байна. Стокгольмын Олон улсын энх тайвны судалгааны институтын судалгаагаар 2019 оны байдлаар 13,865 цөмийн зэвсэг байгаагийн 90 хувийг ОХУ, АНУ эзэмшиж байна.

Олон улсын атомын энергийн агентлагын 2019 оны илтгэлд дурдсанаар 443 цөмийн цахилгаан станц, 226 судалгааны реактор ажиллаж байгаа аж.

Цөмийн зэвсгийг хориглох тухай гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсэгт заасны дагуу зөвшилцөх, хэлэлцүүлэхээр Монгол Улсын Их Хуралд хүргүүлэхээр тогтсон болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР